



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/163.

Мандалговь

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6. "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 11 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтын 4.4 дэх заалт, Засаг даргын зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 7 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирусын халдвар бүртгэгдсэн Эрдэнэдалай, Өлзийт сумд болон аймгийн төвийн хяналтын постуудад шаардлагатай хамгаалах хувцас хэрэглэл, нэг удаагийн түргэвчилсэн оношлуурын нөөцийг бүрдүүлсүгэй.

2. Нөөц бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийн зардлыг хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах 32,750,000 (гучин хоёр сая долоон зуун тавин мянган) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 11,000,000(Арван нэгэн сая) төгрөгийг, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн "Гамшгийн эрсдэлийг бууруулах" арга хэмжээний зардлаас 21,750,000(Хорин нэгэн сая долоон зуун тавин мянган) төгрөгийг тус тус зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Хамгаалах хувцас хэрэглэл, нэг удаагийн оношлуурыг сумдад хэрэгцээ шаардлагыг үндэслэн хуваарилж олгохыг Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Энхтайван)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210449